

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 821 дүгээр дамжааны суралцагч,
дэд хурандаа Г.Бат-Эрдэнэ

ХОРИХ АНГИЙН ДАРГЫН УДИРДАХ АРГА БАРИЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хураангуй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2015 оны батлагдсан орон тоогоор 106 буюу 3.2 хувь нь удирдах алба тушаалд ажиллаж байна. Үүнээс Хорих анги албаны дарга 46 удирдах албан тушаалтан байна. Иймд энэхүү илтгэлээр эдгээр албан тушаалтны манлайлах чадварыг дээшлүүлэхийг зорилоо.

Түлхүүр үг. Арга барил, удирдлага, удирдагч, хорих анги, захиргаадагч, идвэхгүй.

Удирдлагын янз бүрийн зорилтыг шийдвэрлэх явцад хэрэглэдэг тодорхой арга хэрэглүүрийг нийтэд нь удирдах ажилтны арга барил гэдэг. Арга барил бол хөдөлмөрийн хамт олныг хөтлөн жолоодоход нийгэм эдийн засаг, нийгэм улс төр, нийгэм сэтгэл зүйн харьцааг хэрэгжүүлэх хэлбэр юм¹.

Хүн бүр манлайлах чадвар, амьдралаас олсон туршлагатай бөгөөд үүндээ үндэслэн хүмүүстэй харилцаанд ордог. Харин удирдлагын залуурт гарч ирхээрээ тодорхой нэг арга барилаар ажиллаж эхэлнэ².

Хорих анийн даргын эрх мэдэл, удирдах үйл ажиллагааг хангах талаар хуулинд “Засан сайжруулах анги болгон даргатай байх бөгөөд дарга нь шүүх яамнаас баталсан тусгай дүрмүүдийн дотор жагсаасан эрх, үүргийг баримтлан харъяат газрын бичиг хэргийн баг, жагсаалын албан хаагчдыг шууд захирна” гэж онцлон заасан байна³.

Хорих байгууллагын удирдах ажилтнууд удирдлагын ямар арга барилыг түлхүү ашиглаж байгааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлан тогтоосон тохиолдолд хараахан байхгүй байгаа тул цаашид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах ажилтнуудад ямар арга барил нийцтэй болох талаар санал дүгнэлт гаргах нь байгууллагын хөгжил дэвшилд хувь нэмэр болох болов уу гэж үзсэн болно.

¹ Д.Лхаашид. Удирдахуйн нийгэм сэтгэл зүйд үгүүлэгдэж буй аргууд. УБ. 2003.

² Х.Пүрэвдагва. Менежер. \ур чадвар\.. УБ. 1994.

³ 1966 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 3 дугаар заалт

Хорих ангийн даргын удирдлагын арга барилыг 1990 оноос өмнөх үе буюу социалист бүтээн байгуулалтын үед олон жил удирдах ажилд үр бүтээлтэй ажиллаж байсан ахмад ажилтнуудын тухай нийтлэл, дурсамж болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замналаас түүвэрлэн судлаж үзэхэд тухайн үеийн удирдах ажилтан, хорих ангийн дарга нарын нийтлэг удирдах арга барил нь захиргаадах буюу автротар арга барил зонхилож байсан нь тодорхой харагдаж байна. Энэ нь тухай нь цаг үеийн удирдлагын тогтолцооноос шууд хамааралтай Монгол улсад ардын хувьсгал ялснаар Нам төвтэй удирдлага бий болсон бөгөөд удирдлагын бүхий л асуудлыг намын төв хороонд шийдэж гүйцэтгэгч байгууллага түүнийг үг дуугүй даган биелүүлэх чиг үүргийг хүлээж байжээ.

Энэ үеийн менежментийн үйл ажиллагаа нь нэг намын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгууллагыг үүсгэн байгуулах, удирдлагыг зохион байгуулах, бүтцийн асуудал, МАХН-ын улс төрийн товчоо, их, бүгд хурлаар шийддэг байв. Хувьсгалын жилүүд дэх менежментийн асуудал нь социалист гэгдэж байсан орнуудын нэгдсэн жороор боловсруулан, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь ЗХУ-ын заавраар явагдаж байжээ. Удирдлагын хэв маяг \арга барил\ нь нам толгойтой олон үе шаттай, асуудлыг зөвхөн гүйцэтгэх биелүүлэх үйл ажиллагаа явагдаж байсан онцлогтой юм.

Практик амьдралаас сахилга бат дэг журам муутай, дутагдлыг аажмаар засна гэхэд дэндүү их хугацаа шаардах газарт авторитар арга барилтай хатуухан удирдах ажилтныг тавих нь зүйтэй гэж үздэг¹. Удирдлагын энэ арга барил тухайн цаг үедээ түүхэн үүргээ биелүүлж өнөөгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны үндэс суурь нь болсон нь дамжиггүй юм.

1990 оноос хойш буюу одоо үед ажиллаж байгаа хорих ангийн дарга нарын удирдлагын арга барилыг тесстын аргаар судлахад судалгаанд оролцсон нийт 40 удирдах ажилтнаас 30 удирдах ажилтан буюу 62 хувь нь удирдлагын демократ арга барилд хамааралтай үзүүлэлт гарсан бол 9 удирдах ажилтан буюу 19 хувь нь авторат, мөн 9 удирдах ажилтан буюу 19 хувь нь леберал арга барилд бага зэрэг хамааралтай болох нь тогтоогдсон. Үүнээс үзэхэд Хорих ангийн дарга нар демократ арга барилыг өнөөгийн байдлаар ихэвчлэн хэрэглэж байгаа гэж үзэж болно.

¹Д.Лхаашид. Удирдахуйн нийгэм сэтгэл зүйд үгүүлэгдэж буй аргууд. УБ 2003 164 дах тал

Мөн бага тушаалын алба хаагчдаас удирдах ажилтаны арга барилыг тогтоох тесстээр судалгаа авахад нийт судалгаанд оролцогчоос 40 албан хаагч буюу 39 хувь нь хорих ангийн дарга бол демократ арга барилтай гэсэн бол 37 албан хаагч буюу 36 хувь нь леберал, 25 албан хаагч буюу 25 хувь нь авторат арга барилтай гэж хорих ангийн даргыг тодорхойлсон байна.

Дээрх судалгаанаас дүгнэхэд одоогоор ажиллаж байгаа удирдах бүрэлдэхүүний удирдлагын арга барилыг демократ буюу ардчилсан арга барил давамгайлсан гэж үзэж байна. Энэ нь нийгмийн хөгжил дэвшил, ардчиллын тогтолцоотой салшгүй холбоотой илэрч байгаа удирдлагын хамтын оролцоонд тулгууралсан, ардчилсан арга барил юм.

Хорих ангийн даргын удирдлагын арга барилыг дээшлүүлэх арга зам нь удирдахуйн ухааны талаар өргөн мэдлэг эзэмших, түүнд тулгуурлан удирдлагын арга барилын талаар онолын мэдлэгээ дээшлүүлэх шаардлагтай. Өнөөдрийн түвшинд хорих ангийн даргын түлхүү хэрэглэж байгаа нь судалгаагаар тогтоогдсон удирдлагын демократ арга барил нь нийгэм цаг үетэйгээ нийцсэн болох нь 2015 оны үйл ажиллааны үнлэлтээр хууль сахиулах салбартаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тэргүүн байр эзэлсэн явдлаар батлагдаж байна.

Нэгэнт хуримтлагдсан удирдах арга барилыг эзэмшээгүй бол туршилт алдааны аргаар явж бүдрэхээс өөр аргагүй. Гэтэл удирдагчын алдаа нь захиргаанд нь ажиллагсадын хувьд хатуу туршилт болдог нь харамсалтай гэж судлаачид нэгэнт дүгнэсэн байдаг.

Ер нь хүмүүсийг удирдан зохион байгуулах гэдэг бол цорын ганц зөв арга барил, жор гэж байх боломжгүй бөгөөд харин өдөр тутмын бүтээлч эрэл хайгуул, ур ухаан, нөхцөл байдлыг шуурхай мэдрэх мэдрэмж, эв дүй, оюун ухаан шаардсан нарийн төвөгтэй ажил мэргэжил юм. Иймд нийгэм цаг үетэйгээ зохицсон удирдлагын арга барилыг бүрэн судлаж эзэмших нь удирдах ажилтнуудад шаардлагтай. Удирдлагын арга барилууд өөрийн гэсэн онцлого давуу тал болон сул талуудтай байдаг тул удирдлагын арга барилыг бүрэн судлаж өөрсдийн удирдах арга барилаа баяжуулан үйл ажиллагаандаа оновчтой зөв хэрэглэх нь ажлын бүтээмж, ажиллагсадын сэтгэл ханамжинд эерэгээр нөлөөлөх хүчин зүйл болох юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Хорих ангийн онцлог бол гэм буруутай нь шүүхээс тогтоогдсон тодорхой хугацаагаар анх болон олон удаа хорих ял шийтгүүлсэн ялтан хүмүүстэй өдөр тутам харьцаж ажиллах явдал юм. Энэ нь хорих ангийн даргаас эхлээд хянагч албан тушаалтан бүгд хүнтэй харьцаж ажиллах тэр тусмаа гэмт зан үйл, санаа бодол бүхий хүмүүстэй ажиллаж, төрөөс баримтлаж буй ялын бодлогыг

хэрэгжүүлж, нийгэм иргэдийн амгалан тайван байдлыг хангаж байдаг өвөрмөц ажил үүрэг байдаг. Энэ чиг үүргийнхээ дагуу хорих анги олон талт үйл ажиллагаа авч хэрэгжүүлж байдаг тул дарга нар бүх талаар мэдлэг, дадлага эзэмшсэн байх шаарддага нэн тэргүүнд тавигдах нь зүй нь хэрэг юм. Судлаачын хувьд тухайн хүний сэтгэл зүй болон орчны онцлог байдлыг харгалзан ялгавартай хандаж, ажиллах арга барилын дараалал боловсруулж удирдах ажилтаны ажилд тус нэмэр болох болов уу гэж дараах аргачлалыг судалгааны үр дүнд дэвшүүлж байна.

1. Ажиллах объектоо сонгон авч хэнтэй яаж ажиллахаа тогтоон зайлшгүй анхаарал татаж байгаа хэсгийг олж, тэдэнтэй тал бүрээс нь ажиллах. Тухайлбал, залуу, ахмад, тэргүүний алба хаагч, дундач, хамт олноос хоцрогчид гэж ангилан өөр өөр арга барилаар ажиллах. Уг албан хаагчтай ямар арга хэлбэрээр ажиллах нь илүү үр дүнд хүрэхийг урьдчилан тооцож, судлах шаардлагатай болдог юм.

2. Хүнээ судалж үзэсний үндсэн дээр уг хүний шинж байдлыг харгалзан ажиллах арга барилаа сонгодог. Нэг хүн хатуу зарчимч шаардлагад дуртай байхад нөгөө хүн уян зөөлөн харилцахад тааламжгай байх зэргээр хүн бүр өөр өөр өвөрмөц арга барил шаарддаг.

3. Хүн бүртэй өөр өөр аргаар тулж ажиллаад ямар үр дүнд хүрснээ тооцож уг хүнийг идэвхижүүлж хүмүүжүүлснээр хөдөлмөрийн хамт олныг зөв төлөвшүүлэхэд яаж нөлөөлснийг удирдах хүн байнга тооцож, цаашдын зорилтоо тодорхойлдог байх. Үүний үр дүнд хамт олны нийгмийн болон ажлын идэвхи сайжирч, хамт олны дунд аливаа доголдол дутагдал орших орон зайгүй болно.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 821 дүгээр дамжааны суралцагч,
дэд хурандаа Д. Одхүү*

ТОДОРХОЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЭРХ ХАСАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Хураангуй. Энэхүү илтгэлээр тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах ялын тухай ойлголт, түүхэн уламжлал болон тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорьсон болно.

Түлхүүр үг. Хорихоос өөр төрлийн ял, төрийн албан тушаал эрхлэх, мэргэжлийн үйл ажиллагаа, эрх хасах.